

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/01/НА-СТА-ТЕЗ

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: Khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: Amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: Maitsetsegt@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 702723204 Цахим хаяг: Saranchimegts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ	4
1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	5
1.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
1.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	6
1.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
1.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
1.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
1.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
2. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ	11
3. АУДИТЫН ТАЙЛАН	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн	14
3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	14
3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт	16
3.5.3 Авлага	16
3.5.4 Урьдчилгаа	17
3.5.5 Бараа материал.....	17
3.5.6 Үндсэн хөрөнгө	18
3.5.7 Урт хугацаат хөрөнгө оруулалт	19
3.5.8 Өр төлбөр	19
3.5.10 Урт хугацаат өр төлбөр.....	20
3.5.11 Засгийн газрын хувь оролцоо	20
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	21
3.6.1 Төсвийн төлөвлөлт	21
3.6.2 Төсвийн гүйцэтгэл.....	22
3.6.3 Нэмэлт төсөв	24
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	25
3.8 Аудитын гол асуудал.....	26

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	27
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	27
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	27
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	28
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	28
4. Аудитын илрүүлэлт.....	29
4.2.1 Залруулсан алдаа	29
4.2.2 Төлбөрийн акт	29
4.2.3 Албан шаардлага	30
4.2.4 Зөвлөмж	32
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	34

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БНСБС	Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан
ДЭХГ	Дулааны эрчим хүчний газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
СХАА	Санхүүгийн хяналт аудитын алба
СХС	Сум хөгжүүлэх сан
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХК	Хувьцаат компани
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМТ	Эрүүл мэндийн төв

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл.....	14
Хүснэгт 2. Сангуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	15
Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл	16
Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл	17
Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл	18
Хүснэгт 6. Богино хугацаат өр төлбөр.....	20
Хүснэгт 7. Урт хугацаат өр төлбөр	20
Хүснэгт 8. Нийт Засгийн газрын хувь оролцооны үлдэгдэл	21
Хүснэгт 9. Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт.....	24

1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

1.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		41,049,314.9	62,869,681.7
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а.36	15,109,441.1	32,396,757.4
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	15,399,944.6	18,192,919.4
УРЬДЧИЛГАА	7а, 7б	75,475.7	37,700.4
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	10,442,748.9	12,211,953.9
НӨӨЦИЙН БАРАА	9а	21,704.6	30,350.6
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		212,010,261.5	222,947,729.6
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	212,010,261.5	222,947,729.6
Биет хөрөнгө		199,610,009.4	210,496,158.2
Биет бус хөрөнгө	13	12,395,322.1	12,446,641.3
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	4,930.0	4,930.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		253,059,576.4	285,817,411.3
НИЙТ ӨР ТӨЛБӨР		5,494,222.7	4,045,147.6
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	3,260,180.6	1,891,105.4
Өглөг	17а, 17б	3,245,160.4	1,879,575.4
Урьдчилж орсон орлого	18а, 18б	15,020.2	11,530.0
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		2,234,042.1	2,154,042.1
Урт хугацаат зээл	20а, 20б	2,234,042.1	2,154,042.1
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		247,565,353.7	281,772,263.8
Засгийн газрын хувь оролцоо		247,565,353.7	281,772,263.8
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		75,531,832.9	75,531,832.9
Өмч /төрийн/ /ТӨҮГ/		760,054.3	760,054.4
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		7,072,426.5	7,153,256.5
Хуримтлагдсан үр дүн		101,303,198.0	135,741,464.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		62,897,842.0	62,585,656.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		253,059,576.4	285,817,411.3

1.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тодруулга	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		158,069,346.06	186,255,713.7
ТАТВАРЫН ОРЛОГО		25,758,479.81	31,542,025.6
Орлогын албан татвар		11,889,853.55	14,661,378.9
Хувь хүний орлогын албан татвар		12,451,642.22	15,243,449.2
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-561,788.67	-582,070.2
Хөрөнгийн албан татвар		5,237,539.66	7,095,256.7
Бусад татвар, төлбөр, хураамж		8,631,086.60	9,785,390.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 16	114,478,250.88	122,408,738.6
Нийтлэг татварын бус орлого		45,834,169.16	53,907,791.3
Хөрөнгийн орлого		188,414.09	157,958.6
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		68,455,667.64	68,342,988.7
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		17,832,615.37	32,304,949.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 26	111,548,270.87	120,567,254.4
УРСГАЛ ЗАРДАЛ		111,548,270.87	120,321,518.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		99,359,833.53	114,197,970.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		50,976,181.80	52,787,894.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		6,508,069.73	7,257,182.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		14,855,793.38	15,455,441.4
Хангамж, бараа материалын зардал		2,251,466.21	3,135,435.8
Нормативт зардал		4,420,908.32	7,764,213.3
Эд хогшил, урсгал засварын зардал		514,937.22	458,811.6
Томилолт, зочны зардал		158,726.22	180,257.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,573,551.22	1,605,834.8
Бараа үйлчилгээний бусад зардал		17,100,199.44	25,552,899.0
ТАТААС		476,832.50	337,291.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		11,711,604.84	5,786,256.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.00	245,735.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		46,521,075.19	65,688,459.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		62,936.11	111,425.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		21,438,965.15	31,715,710.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		25,145,046.16	34,084,173.6

1.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	129,622,146.6	160,177,146.8
ТАТВАРЫН ОРЛОГО	25,758,379.8	31,534,784.9
Орлогын албан татвар	11,889,753.5	14,661,988.7
Хувь хүний орлогын албан татвар	12,451,542.2	15,244,059.0
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(561,788.7)	(582,070.2)
Хөрөнгийн албан татвар	5,237,539.7	7,095,256.7
Бусад татвар, төлбөр, хураамж	8,631,086.6	9,777,539.5
Бусад нийтлэг төлбөр, хураамж	840,447.7	994,942.7
Газрын төлбөр	3,692,024.6	3,873,256.4
Байгалийн нөөц ашигласны төлбөр	4,098,614.3	4,909,340.4
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	85,766,713.8	98,112,592.6
Нийтлэг татварын бус орлого	17,122,632.1	29,611,645.3
Хөрөнгийн орлого	188,414.1	157,958.6
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	68,455,667.6	68,342,988.7
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	18,097,053.0	30,529,769.2
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	100,503,873.3	105,128,139.6
УРСГАЛ ЗАРДАЛ	100,503,873.3	105,128,139.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	88,329,973.9	98,842,625.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	50,533,992.8	52,754,709.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,736,330.5	7,260,041.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,992,878.8	15,440,911.0
Хангамж, бараа материалын зардал	2,537,913.7	4,059,770.4
Нормативт зардал	4,061,324.1	4,302,569.6
Эд хогшил, урсгал засварын зардал	435,101.7	553,134.7
Томилголт, зочны зардал	153,500.9	182,152.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,621,264.3	1,708,199.3
Бараа үйлчилгээний бусад зардал	6,257,667.0	12,581,137.7
ТАТААС	476,832.5	337,291.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,697,066.9	5,948,222.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	29,118,273.3	55,049,007.2
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	23,036,236.1	34,308,591.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,036,236.1	34,308,591.3
Дотоод эх үүсвэрээр	23,036,236.1	34,308,591.3
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(23,036,236.1)	(34,308,591.3)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(3,329,145.7)	(3,453,099.6)
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	3,329,145.7	3,453,099.5
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,752,891.5	17,287,316.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,356,549.6	15,109,441.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,109,441.1	32,396,757.4

1.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч/
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	218,295,787.2	0.0	218,295,787.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-244,089.0	0.0	-244,089.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	218,051,698.1	0.0	218,051,698.1
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	88,131.5	0.0	88,131.5
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	4,280,477.9	0.0	4,280,477.9
Тайлант үеийн үр дүн	25,145,046.2	0.0	25,145,046.2
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	247,565,353.7	0.0	247,565,353.7
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	247,565,353.7	0.0	247,565,353.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	354,092.4	0.0	354,092.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	247,919,446.1	0.0	247,919,446.1
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-312,185.9	0.0	-312,185.9
Өмчид гарсан өөрчилөлт	80,830.0	0.0	80,830.0
Тайлант үеийн үр дүн	34,084,173.6	0.0	34,084,173.6
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	281,772,263.8	0.0	281,772,263.8

1.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	108,663,755.1	96,225,551.7
УРСГАЛ ЗАРДАЛ	87,619,480.9	81,771,294.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	85,756,508.6	80,041,760.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,950,181.6	50,073,635.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,992,915.2	6,556,364.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,616,163.6	11,881,078.2
Хангамж, бараа материалын зардал	1,873,378.5	1,815,237.8
Нормативт зардал	2,885,578.7	2,012,687.2
Эд хогшил, урсгал засварын зардал	462,999.7	459,275.2
Томилолт, зочны зардал	286,085.3	170,560.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	510,994.6	458,860.1
Бараа үйлчилгээний бусад зардал	8,178,211.4	6,614,062.2
ТАТААС	337,291.7	337,291.7
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	102,000.0	102,000.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	235,291.7	235,291.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,525,680.6	1,392,242.1
Бусад урсгал шилжүүлэг	1,525,680.6	1,392,242.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,211,336.4	12,326,627.9
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	3,832,937.8	2,127,629.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	108,663,755.1	99,190,069.1
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	58,672,097.8	56,494,733.9
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	36,584,711.2	39,048,096.2
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	779,030.1	516,167.8
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	12,627,916.0	3,131,071.2
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	0.0	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл □	0.0	3,017,091.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл □	0.0	5,981,609.0

1.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,505,072.0
УРСГАЛ ЗАРДАЛ	10,413,017.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,688,913.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	358,446.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,263.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	187,344.0
Хангамж, бараа материалын зардал	416,824.5
Нормативт зардал	971,631.9
Эд хогшил, урсгал засварын зардал	306,294.0
Томилолт, зочны зардал	10,676.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	458,625.6
Бараа үйлчилгээний бусад зардал	4,939,806.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,724,104.3
Бусад урсгал шилжүүлэг	2,234,730.7
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	489,373.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	92,054.7
Дотоод эх үүсвэрээр	92,054.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,563,413.4
Нэмэлт санхүүжилтийн орлого	10,563,413.4
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	61,141.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	58,344.2

2. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn

2022.04.20 № 01/261
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Д.МӨНХБААТАР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Төв аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБООУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022 № 01/261

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар танд танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн зарцуулалт, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Майцэцэг, Ц.Саранчимэг, аудитор Г.Баянжаргал, Д.Бямбасүрэн, Ж.Бямбацогт, Т.Хүрэлбаатар, Б.Нямсүрэн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүллээ.

Төв аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 01/548 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан биелүүлж, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлт, хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөр, хэрэгжилтэд тавих хяналт, аймгийн төсөв, түүний төлөвлөлт, гүйцэтгэл, тайланд, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайланд, аймгийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалтад тавих хяналтыг хэрэгжүүлж, төр, засгийн бодлого шийдвэрийг иргэддээ сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг.

Төв аймаг нь 2021 оныг Эрүүл мэнд хүний хөгжлийг дэмжих жил болгон зарлаж, “Төрийн үйлчилгээний бүтээмжийг нэмэгдүүлэх замаар аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн тогтвортой өсөлтийг хангана” гэсэн зорилтыг хэрэгжүүлж, 2020 оны үйл ажлаараа улсдаа тэргүүн байр эзэлсэн, мөн ISO-н чанарын магадлал хийгдсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАТ хууль, Татварын болон Нийгмийн даатгалын хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

Төв аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үйл ажиллагаанд ашиглах болон төсвийн байгууллага, төсөл сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Актив Аудит ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, аймгийн Засаг даргын захирамжаар баталж, 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн мөрдөж байна.

Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6-д “Төв төрийн сан нь аймаг, нийслэлийн төрийн сан болон төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд, аймаг, нийслэлийн төрийн сан нь сум, дүүргийн төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу аймгийн Санхүү төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн төрийн сангийн үйл ажиллагаанд, хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг байна.

Мөн хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасны дагуу Төв аймгийн Засаг даргын 2015 оны А/52 тоот захирамжаар Санхүү хяналт аудитын албыг 7 орон тоотойгоор байгуулан, тус албаны дүрмийг батлан ажиллаж байна.

Санхүү хяналт аудитын алба нь тайлангаа шалгуулагч байгууллага болон дотоод аудитын хороонд тайлагнадаг ба тайлант хугацаанд хийгдсэн шалгалтаар нийт 2,968.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж, үүнээс зөрчлийг арилгуулахаар 2,596.8 сая төгрөгийн албан шаардлага, 372.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, биелэлтийг ханган ажилласан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны үйл ажиллагаанд хамаарах байгууллагуудын мэдээлэлд 2021 оны 12 дугаар сарын байдлаар хийсэн дотоод хяналт шалгалтаар бүгд мэдээлбэл зохих 32523 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 23852, хугацаа хоцроосон 5982, огт мэдээлээгүй 2088 мэдээлэл, хэрэгжилтийг 92,0 хувиар тооцсон байна.

Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг жилд 2 удаа тусгай удирдамж төлөвлөгөөний дагуу бүх сум байгууллагуудаа хийж, зөвлөн тусалдаг байна.

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Сангийн яам, аймгийн СТСХ нь тухай бүр зөвлөмж зааварчилгаа өгдөг ба 2021 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нягтлан бодох болон анхан шатны бүртгэл хөтлөлт, албан хаагчдын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтад хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБООУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Засаг даргын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн орлогын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Засаг даргын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн орлого 158,069.4 сая төгрөгөөс 1,5 хувиар буюу 2,371.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0 хувиар буюу 1,778.3 сая төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг Төв аймгийн Засаг даргын өмнөх оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн орлогын дүнгээс тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг аймгийн Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн орлого 186,255.7 сая төгрөгөөс 1,5 хувиар буюу 2,793.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75,0 хувиар буюу 2,095,4 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас материаллаг байдлын түвшин 422.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдал 317.1 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Төв аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангаар мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 15,109.4 сая төгрөг, тайлант оны үйл ажиллагааны мөнгөн орлого 283,714.0 сая төгрөг, харьяа байгууллагуудын урсгал санхүүжилтэд 228,568.3 сая төгрөгийг, хөрөнгө оруулалтын санхүүжилтэд 34,405.3 сая төгрөгийг, эргэн төлөгдөх зээлд 3,453.1 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 32,396.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тайлагнагдсан байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эхнээс 17,287.3 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 8,677.4 сая төгрөг, тусгай сангуудын үлдэгдэл 9,199.9 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 98.5 хувь буюу 31,928.8 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 0,2 хувь буюу 58.3 сая төгрөг нь нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд, 1.3 хувь буюу 408.9 сая төгрөг нь арилжааны банк дахь харилцах дансанд, 0.7 сая төгрөг нь байгууллагуудын кассад байршиж байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	17.1	0.7	-16.4
Төрийн сангийн харилцах	14,716.3	31,928.8	17,212.5
Нэмэлт дансны харилцах	-	58.3	58.3
Банканд байгаа бэлэн мөнгө	376.0	408.9	32.9
Дүн	15,109.4	32,396.7	17,287.3
<i>Үүнээс: байгууллагын төрлөөр</i>			
Орон нутгийн ерөнхий орлого	8,548.4	17,225.8	8,677.4
Сумын орлогын дүн	4,153.2	6,763.9	2,610.7
Аймгийн ерөнхий орлогын дүн	4,395.2	10,461.9	6,066.7
Төсөвт байгууллага	1,041.1	494.2	-546.9
Төсөл/ сан	5,460.9	14,660.8	9,199.9
ТӨҮГ болон ОНӨҮГ	59.0	16.0	43.0
Дүн	15,109.4	32,396.7	17,287.3

Эх сурвалж: Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас

Төрийн сангийн харилцах дансанд байршиж буй 31,928.8 сая төгрөгийн үлдэгдлээс орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 17,225.8 сая төгрөг, сангуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 14,279.0 сая төгрөг, төсөвт газруудын үлдэгдэл 262.0 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлсэн үлдэгдэл 162.0 сая төгрөг байна.

2021 оны жилийн эцсийн кассын үлдэгдэл нийт 0.7 сая төгрөг нь эмийн эргэлтийн сан, Архуст сумын ерөнхий боловсролын сургууль, Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн үлдэгдэл байна.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд байршиж буй 58.3 сая төгрөг нь Эрүүл мэндийн төвүүдийн эрүүл мэндийн даатгалын сангаас авсан санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл байна.

Аймгийн орон нутгийн ерөнхий орлогын мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 8,677.4 сая төгрөгөөр өссөн нь аймаг, сумын орон нутгийн давсан орлогын үлдэгдэл, орон нутгийн байгууллагуудаас жилийн эцэст зарцуулаагүй төсвийн үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Сангуудын мөнгөн хөрөнгө

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дах тусгай зориулалттай сангуудын чөлөөт үлдэгдэл оны эцэст 14,660.8 сая төгрөгөөр тайлагнагдсан байна. Үүнээс төрийн сангийн харилцах дансанд 14,279.0 сая төгрөг, арилжааны банк дахь харилцах дансанд 381.1 сая төгрөг, байгууллагын кассад 0.7 сая төгрөг тус тус байршиж байна.

Хүснэгт 2. Сангуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Касст байгаа мөнгө	/сая төгрөг/	
				Банк дахь бэлэн мөнгө	Арилжааны банк
Эмийн эргэлтийн сан	323.0	378.6	-	378.6	-
Орон нутгийн хөгжлийн сан	2,134.9	3,957.6	-	-	3,957.6
Сум хөгжүүлэх сан	858.8	1,698.4	-	-	1,698.4
Байгаль хамгаалах сан	332.8	347.2	-	-	347.2
Мал хамгаалах сан	15.9	102.0	-	-	102.0
Хөрөнгө оруулалт, хөгжлийн барьцаа сан	1,672.6	7,829.8	-	-	7,829.8
Тариалан дэмжих сан	0.6	0.7	0.7	-	-
Халамжийн сан	0.1	-	-	-	-
Аймаг хөгжүүлэх сан	114.8	339.1	-	2.5	336.6
Хөрөнгө, оруулалт	7.4	7.4	-	-	7.4
Дүн	5,460.9	14,660.8	0.7	381.1	14,279.0

Эх сурвалж: Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас

Тайлант онд тусгай зориулалттай сангуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эхнээс 9,199.9 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сан 1,822.7 сая төгрөг, сум хөгжүүлэх сан 839.5 сая төгрөг, барьцаа сан 6,157.1 сая төгрөг, аймаг хөгжүүлэх сан 224.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна. Энэ нь Ковид-19 цар тахлаас болон Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолоор орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт хөрөнгө оруулалтыг царцаасан болон СХС-ийн зээлийн эргэн төлөлт сайжирсантай холбоотой байна.

Аймаг хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 224.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 2009, 2015 оны Хас банктэй хамтран ажиллах гэрээгээр харилцан тохиролцож жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийг аймаг, орон нутагт хэрэгжүүлэх зорилгоор "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн сан" дансанд 179.0 сая төгрөг байршуулсныг дуусгавар болгон нийт зардлыг тооцон 190.4 сая төгрөгийг буцаан төрийн сангийн дансанд шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Тайлант онд хөрөнгө оруулалт, хөрөнгийн барьцаа сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 6,157.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 397 дугаар тогтоолоор ковид-19 цар тахлын нөлөөллөөс үүдэн улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэхээр батлагдаж гэрээ нь байгуулагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг тус дансанд байршуулсан нь нөлөөлсөн байна.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт байхгүй.

3.5.3 Авлага

Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 15,399.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 18,192.9 сая төгрөгөөр тайлагнасан ба өмнөх онтой харьцуулахад 2,793.0 сая төгрөгөөр буюу 18,2 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+) Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	33.7	89.0	55.3
Төлбөртэй үйлчилгээний авлага	0.2	343.2	343.0
Татаас, санхүүжилтийн авлага	-	3.1	3.1
Зээлийн хүүгийн авлага	106.4	85.7	-20.7
Дансны авлага /ТӨҮГ/	3.4	5.6	2.2
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	118.7	13.4	-105.3
Бусад авлага	12,924.4	15,519.8	2,595.4
Зээлийн авлага	2,213.1	2,133.1	-80.0
Дүн	15,399.9	18,192.9	2,793.0
<i>Үүнээс: байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	322.8	2,831.7	2,508.9
Төсөл/ сан	11,963.3	12,505.5	542.2
Төрийн сан	2,214.6	2,144.3	-70.3
ТӨҮГ болон ОНӨҮГ	899.2	711.4	-187.8
Дүн	15,399.9	18,192.9	2,793.0

Эх сурвалж: Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас

Байгууллагын төрлөөр авч үзвэл төсөвт байгууллагын авлага өмнөх оноос 2,508.9 сая төгрөг буюу 8.8 дахин, төсөл, сан 542.2 сая төгрөг буюу 4,5 хувиар тус тус өсч, ОНӨААТҮГ 187.8 сая төгрөг буюу 20,9 хувиар буурсан байна.

Төсөвт байгууллагуудын авлагын өсөлтийн 86,1 хувийг буюу 2,404.9 сая төгрөгийг сумдын эрүүл мэндийн төвийн авлага эзэлж байна. ОНӨААТҮГ-ын авлага 711.4 сая төгрөг нь Төв Чандмань ДЭХГ-ын байгууллагаас авах авлага 698.0 сая төгрөг, татвар НДШ-ийн авлага 13.4 сая төгрөг байна.

Төсөл, сангийн авлага 12,505.6 сая төгрөгийн үлдэгдлийн бүтцийг харуулбал:

- 147.2 сая төгрөг буюу 1,2 хувийг Эмийн эргэлтийн сан
- 3,858.1 сая төгрөг буюу 30,8 хувийг Аймаг хөгжүүлэх сан
- 444.4 сая төгрөг буюу 3,6 хувийг Орон нутгийн хөгжлийн сан
- 7,798.3 сая төгрөг буюу 62,4 хувийг Сум хөгжүүлэх сан
- 79.6 сая төгрөг буюу 0,6 хувийг Тариалан эрхлэлтийг дэмжих сан
- 177.8 сая төгрөг буюу 1,4 хувийг Мал хамгаалах сан тус тус эзэлж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 444.4 сая төгрөгийн авлага нь хөрөнгө оруулалтын ажил бүрэн хийгдэж, ажлыг хүлээн аваагүйгээс шинээр үүссэн авлага байна.

Аудитын илрүүлэлт:

Харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:

- Сум хөгжүүлэх сан, эмийн эргэлтийн сан болон төсөвт байгууллагуудын 7,322.4 сая төгрөгийн авлагыг э-тайланд тооцоо нийлсэн акт байхгүйгээр нэгтгэсэн байна.

- Төсвийн жил дуусч байгаатай холбогдуулан төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг харилцагч, бэлтгэн нийлүүлэгч байгууллага руу шилжүүлэн авлага үүсгэсэн, зориулалт бус зардал гаргасан 3.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны оны эхний үлдэгдэл 75.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 37.7 сая төгрөг болж, 37.8 сая төгрөгөөр буурсан байна. Урьдчилгаа дансны үлдэгдэл 37.7 сая төгрөг нь орон нутгийн өмчит Төв Чандмань ДЭХГ-ын нүүрс бэлтгэхтэй холбоотой бэлтгэн нийлүүлэгчид шилжүүлсэн төлбөрийн үлдэгдэл байна.

3.5.5 Бараа материал

Төв аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бараа материалын оны эхний үлдэгдэл 10,464.4 сая төгрөг байснаас 1,777.9 сая төгрөгөөр өсөж, оны эцэст 12,242.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Бараа материалын тодруулгаар тайлант онд 21,797.8 сая төгрөгөөр нэмэгдэж, 20,019.9 сая төгрөгөөр хасагдсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	1,785.8	1,557.2	-228.6
Эм боох материал	1,032.3	2,543.7	1,511.4
Дуусаагүй үйлдвэрлэл	56.1	76.0	19.9
Бэлэн бүтээгдэхүүн	54.6	57.7	3.1
Бичиг хэргийн материал	156.2	194.9	38.7
Аж ахуйн материал	2,566.2	2,809.9	243.7
Сэлбэг хэрэгсэл	174.4	185.4	11.0
Түлш, шатах тослох материал	101.3	78.9	-22.4
Барилгын засварын материал	46.4	55.9	9.5
Хүнсний материал	170.3	216.8	46.5
Бусад хангамжийн материал	4,108.9	4,224.4	115.5
Биологийн хөрөнгө	7.7	7.7	-
Мал амьтад	182.5	203.0	20.5
Нөөцийн бараа	21.7	30.3	8.6
Дүн	10,464.4	12,242.3	1,777.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	8,998.4	10,862.8	1,864.4
Төсөл/ сан	-	-	-
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,466.0	1,379.5	-86.5
Дүн	10,464.4	12,242.3	1,777.9

Эх сурвалж: Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас

Нийт бараа материалыг байгууллагын бүтцээр нь авч үзвэл 10,862.8 сая төгрөг буюу 88,7 хувийг төсөвт байгууллага, 1,379.5 сая төгрөг буюу 11,3 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бараа материал эзэлж байна.

Бараа материалын үлдэгдэл оны эхнээс өссөн нь цар тахлаас урьдчилан сэргийлэх болон эмчилгээний материалын нөөц бүрдүүлснээс эм боох материал 1,511.4 сая төгрөгөөр, аж ахуйн материал 243.7 сая төгрөгөөр, бусад хангамжийн материал 115.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Бараа материалын эцсийн үлдэгдэлд 2,543.7 сая төгрөгийн эм боох материал байгаа нь оны эхний үлдэгдлээс 2.5 дахин өссөн байна. Эм боох материалын эцсийн үлдэгдлийн 55,6 хувийг Зуунмод сумын өрхийн эмнэлэг 910.2 сая төгрөг, Жаргалант сумын эрүүл мэндийн төв 80.5 сая төгрөг, Бүрэн сумын эрүүл мэндийн төв 80.3 сая төгрөг, Батсүмбэр

сумын эрүүл мэндийн төв 76.7 сая төгрөг, Жаргалант сумын эргэлтийн эмийн сан 76.2 сая төгрөг, Мөнгөнморьт сумын эрүүл мэндийн төв 70.6 сая төгрөгийн үлдэгдэл эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

Харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:

- Бараа материалын худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулдаггүй нийтлэг зөрчил байна.
- Төв аймгийн Засаг даргын Тамгын газар нь тайлант онд аймгийн Засаг даргын А/551 тоот захирамжаар 2021 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр Бурам фарм ХХК-д 51.0 сая төгрөг, А/754 тоот захирамжаар 2021 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Монгол эм импекс ХК-д 20.4 сая төгрөг, Нэгүн арвижих ХХК-д 13.6 сая төгрөг, нийт 85.0 сая төгрөгөөр 5000 ширхэг түргэвчилсэн оношлуур худалдан авахаар үнийг шилжүүлжээ. Аймгийн Засаг даргын захирамжаар “хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж тайлагнахыг аймгийн Эрүүл мэндийн газарт үүрэг болгосон” боловч 85.0 сая төгрөгөөр худалдан авсан 5000 ширхэг оношлуурын санхүүгийн анхан шатны баримт байхгүй, санхүүгийн тайланд тусгаагүй зөрчилд албан шаардлага өгөгдсөн.
- Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын аюулгүйн нөөцийн өвс тэжээлийн тооцоог хийж үзэхэд нийт 22.3 сая төгрөгийн үнэ бүхий 1000 шуудай тэжээл, 234 боодол өвсийг орлогод авалгүй зарцуулсан, Засаг дарга болон багийн дарга, нягтлан бодогч нярав нар нь өвс тэжээлийн мөнгийг харилцах дансанд тушаалгүй хувийн данс болон бэлнээр авч тэжээл худалдан авсан, өвөлжилт хүндэрсэн үед малчин болон мал бүхий иргэдэд хямд үнээр олгох өвс, тэжээлийг үндэслэлгүй үнэ нэмж зарсан, өмнөх Засаг дарга 600 шуудай тэжээлийн үнийг төлөлгүй авсан зөрчилд албан шаардлага өгөгдсөн. /Уг зөрчилд СХАА-аас акт бичигдсэн/
- Заамар сумын Төвийн цэцэрлэг, Шижир алт хүүхдийн цэцэрлэг, Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургууль нь хүүхдийн хоол хүнсний материалын зарцуулаагүй төсвийн үлдээгдлийг нэгдсэн дансанд төвлөрүүлэлгүй, нөөцөлсөн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Төв аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 265,419.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 287,463.3 сая төгрөг болж, оны эхнээс 22,044.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өсөлт (+), Бууралт (-)	
Барилга, байгууламж, орон сууц	176,959.4	191,988.3	15,028.9	
Авто-тээврийн хэрэгсэл	10,925.9	11,288.7	362.8	
Машин тоног төхөөрөмж	20,501.1	22,849.0	2,347.9	
Тавилга, аж ахуйн эд хогшил	8,410.4	8,868.8	458.4	
Зам, гүүрний байгууламж	16,913.1	18,553.4	1,640.3	
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	920.2	926.1	5.9	
Бусад үндсэн хөрөнгө	15,968.0	17,838.6	1,870.6	
Дуусаагүй барилга, байгууламж	1,253.7	1,449.3	195.5	
Ном	965.7	1,029.5	63.8	
Программ хангамж	269.6	260.5	-9.1	
Бусад биет бус хөрөнгө	12,326.9	12,406.2	79.3	
Биологийн хөрөнгө	4.9	4.9	-	
Дүн	265,419.0	287,463.3	22,044.3	
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
Төсөвт байгууллага	245,836.6	267,225.6	21,389.0	
Төсөл/ сан		3.9	3.9	

Төрийн сан			
ТӨҮГ болон ОНӨҮГ	19,582.4	20,233.8	651.4
Дүн	265,419.0	287,463.3	22,044.3

Эх сурвалж: Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас

Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаар тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 2,522.3 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 15,429.8 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 763.3 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан 3,123.9 сая төгрөг, бусад 3,552.0 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 814.4 сая төгрөгөөр нэмэгдсэн, эрх бүхий байгууллагын шийдвэрээр худалдан борлуулсан 218.5 сая төгрөг, акталж данснаас хассан 2,127.7 сая төгрөг, балансаас баланст шилжүүлсэн 600.6 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 4.5 сая төгрөг, бусад 158.2 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 1,051.8 сая төгрөг байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлийн 92,9 хувь буюу 267,225.6 сая төгрөгийг төсөвт байгууллагууд, 7,0 хувь буюу 20,233.8 сая төгрөгийг орон нутгийн өмчит газрууд, 0,1 хувь буюу 3.9 сая төгрөг нь төсөл сангийн үндсэн хөрөнгийн үлдэгдэл эзэлж байна.

Дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй нийт 1,449.3 сая төгрөгийн хөрөнгө нь Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газрын 58.0 сая төгрөгийн 24 айлын орон сууц, Баян сумын Засаг даргын Тамгын газрын 7.4 сая төгрөгийн цайны газрын барилга, Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 260.0 сая төгрөгийн үерийн далан, Төв Чандмань ДЭХГ-ын 1,123.8 сая төгрөгийн Дулааны станцын барилга байна.

Аудитын илрүүлэлт:

Харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:

- Үндсэн хөрөнгө, бараа материалыг буруу ангилан бүртгэдэг, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлж данс бүртгэлд тусгаагүй зөрчил буурахгүй байна.
- Эд хөрөнгийн тооллогыг нүд үзэн тоолж чанартай хийдэггүй, тооцоог боддоггүй, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гаргадаггүй зөрчил давтан гарсаар байна.
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-т автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх гэж заасан байхад 118.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авалт хийсэн зөрчилд албан шаардлага өгсөн.

3.5.7 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт байхгүй

3.5.8 Өр төлбөр

Төв аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат өр төлбөр дансны оны эхний үлдэгдэл 3,260.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1,891.1 сая төгрөг болж, оны эхнээс 1,369.1 сая төгрөгөөр буурсан байна.

Богино хугацаат өр төлбөр буурахад дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ий ногдол ашгаас Төв аймгийн хүн амд ногдох хэмжээний 678.2 сая төгрөгийг Сэргэлэн сумын татварын дансанд шилжүүлснийг төлбөрийн акт тавьж барагдуулсан

- Төв Чандмань ДЭХГ-ын өглөг оны эхэнд 1,892.7 сая төгрөг, оны эцэст 1,070.8 сая төгрөг болж 821.9 сая төгрөгөөр буурсан нь цахилгааны төлбөр болон нүүрсний үнийн өрийг барагдуулсантай холбоотой байна.

Хүснэгт 6. Богино хугацаат өр төлбөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +/- Бууралт /-/
Ажилчидтай холбогдсон өглөг	43.5	114.1	70.6
Бараа үйлчилгээний зардлын өглөг	82.7	184.4	101.8
Байгууллагад төлөх өглөг	3,113.1	1,168.0	(1,945.1)
Хувь хүмүүст төлөх өглөг	2.5	3.5	0.9
Татварын өглөг /ТӨҮГ/	3.2	291.4	288.3
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	0.2	118.2	118.0
Дансны өглөг /ТӨҮГ/	0.0	-	(0.0)
Урьдчилж орсон орлого	15.0	11.5	(3.5)
Дүн	3,260.2	1,891.1	(1,369.1)
Үүнээс: Байгууллагын төрлөөр			-
Төсөвт байгууллага	842.7	444.5	(398.2)
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,921.3	1,076.3	(845.0)
Төсөл/ сан	496.2	370.3	(125.8)
Дүн	3,260.2	1,891.1	(1,369.1)

Эх сурвалж: Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас

Аудитын илрүүлэлт:

Харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:

- Төсөвт байгууллагууд харилцагч байгууллагатай үүссэн 149.4 сая төгрөгийн авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага өгөгдсөн.
- Татварын албаны аж ахуй нэгж, байгууллагын тодорхойлолтыг үндэслэн цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого болон Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татвар, орон нутгийн орлогын тооцооллыг тулгахад татварын орлогын үлдэгдлүүд зөрүүтэй зөрчилд албан шаардлага бичигдсэн байна.

3.5.10 Урт хугацаат өр төлбөр

Төв аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд урт хугацаат өр төлбөр дансны 2021 оны эхний үлдэгдэл 2,234.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 2,154.0 сая төгрөг болж 80.0 сая төгрөгөөр буурсан байна. Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх зээлийн 2,213.1 сая төгрөгийн үлдэгдэл 80.0 сая төгрөгөөр буурч, Төв Чандмань ДЭХГ-ын эрсдэлийн санд өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт 7. Урт хугацаат өр төлбөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +/- Бууралт /-/
ЗГ-ын дамжуулан зээлдүүлэх зээл	2,213.1	2,133.1	-80,0
Нөөц /өр төлбөр/ ТӨҮГ	20.9	20.9	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,234.0	2,154.0	-80.0

Эх сурвалж: Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас

3.5.11 Засгийн газрын хувь оролцоо

Төв аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Засгийн газрын оролцоо дансны эхний үлдэгдэл 247,565.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 281,772.3 сая төгрөг болж, оны эхнээс 33,852.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт Засгийн газрын хувь оролцооны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	НББ-ийн бодлогын өөрчлөлт	/сая төгрөг/	
			Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	83,364.3	-	83,445.1	80.8
Дахин үнэлгээний нөөц	62,897.8	-	62,585.7	-312.1
Хуримтлагдсан үр дүн	101,303.2	354.1	135,741.5	34,084.2
Дүн	247,565.3	354.1	281,772.3	33,852.9

Эх сурвалж: Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас

Засгийн газрын оруулсан капитал дансны эхний үлдэгдэл 83,364.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 83,445.1 сая төгрөг болж, 80.8 сая төгрөгөөр өссөн нь Төв Чандмань ДЭХГ-ын хөрөнгө оруулалтын өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцооны нийт дүнд дараах үзүүлэлтүүд нөлөөлсөн байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн алдааны залруулгаар 354.1 сая төгрөгийг аймгийн ЗДТГ, БОАЖГ, Төв чандмань ДЭХГ орон нутгийн өмчит газар болон 16 сумын тайлан бүртгэлд залруулга хийгдсэн байна.
- Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц 312.1 сая төгрөгөөр буурсан нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн актлагдсан болон ашиглаж болох шилжсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний дүнгээр өөрчлөгдсөн байна.
- Өмч 80.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Төв Чандмань ДЭХГ-ын хөрөнгө оруулалтын өөрчлөлтийг тусгасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн алдааны залруулга 354.1 сая төгрөгийн 70,8 хувь буюу 250.5 сая төгрөгийг Цээл сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд хийгдсэн залруулга эзэлж байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн орлогын төлөвлөлт:

Төв аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн III хуралдааны “Аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 03 дугаар тогтоолоор аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 18,347.0 сая төгрөгөөр, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор сумын төсөвт төвлөрүүлэх орлогыг 8,243.1 сая төгрөгөөр, нийт 26,590.1 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь УИХ-аас аймгийн орон нутгийн төсвийн 2021 оны нийт орлогыг 23,007 сая төгрөг байхаар тооцсоноос 3,583.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Төв аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн “Аймгийн 2021 оны төсвийн тодотгол батлах тухай” 01 дүгээр тогтоол болон сумдын ИТХ-ын төсөв тодотгосон тогтоолд зааснаар нийт 26,947.1 сая төгрөгөөр батлагдсан нь анхны баталсан төсвөөс 357.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь хувь хүний орлогын албан татварын буцаан олголт 900.0 сая төгрөг байсныг 585.0 сая төгрөг болгон 315.0 сая төгрөгөөр бууруулж, Зуунмод сумын орон нутгийн төсвийн орлогыг 42.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Сумдын ИТХ-ын тогтоолоор батлагдсан татварын ба татварын бус орлогыг, Төсвийн ерөнхийлөн захирагч онлайнд суурилсан FISCAL-B системд зөрүүтэй тусгасан зөрчил илэрлээ. Энэ нь Төв аймгийн Засаг даргын 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн А/334 дугаар захирамжаар 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар сумдын төрийн сангийн Ерөнхий орлогын дансанд үлдсэн, төсвийн шилжих үлдэгдэлд орж батлагдаагүй орлогын үлдэгдэл болох 866.6 сая төгрөгийг гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, Ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ болон 2020 оны орон нутгийн сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагчдын тэтгэмжид зарцуулахаар зохицуулалт хийхийг сумдын Засаг даргад үүрэг болгосныг бүрэн хэрэгжүүлээгүй гэсэн тайлбар өгч байна.

2021 онд зарцуулах зарлага төлөвлөлт:

Аймгийн Засаг даргын 2021 онд зарцуулах зарлагын нийт хэмжээг, аймаг, сумдын ИТХ-ийн хуралдаанаар 104,222.7 сая төгрөгөөр баталсныг 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн II хуралдааны 01 дүгээр тогтоолоор тодотгон 108,663.7 сая төгрөгөөр буюу 4,441.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 108,663.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 87,619.5 сая төгрөгийг урсгал зардалд, 17,211.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх цэвэр зээлд 3,832.9 сая төгрөг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 58,672.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 36,584.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 8,780.0 сая төгрөгийг урьд оны шилжих үлдэгдлээс, 779.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 3,847.9 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан 2021 онд зарцуулах төсвийн зарлагын төлөвлөгөөг э-тайлангийн төлөвлөгөөтэй тулган шалгахад 27 суманд нийт 877.5 сая төгрөг зөрүүтэй нийтлэг зөрчил илэрсэн. Энэ нь сумдын ИТХ-ын төсөв баталсан тогтоолын өөрчлөлтийг бүрэн тусгадаггүй, сумын ИТХ хуралдсанаас хойш аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/767 дугаар захирамжаар сургууль, цэцэрлэгийн тусгай зориулалтын шилжүүлэгт зохицуулалт хийгдсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл:

Аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөөгөөр улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 9,670.9 сая төгрөг, ОНХНС-ийн орлогын шилжүүлэг 9,333.7 сая төгрөг, ТЗШ-ийн байгууллагын санхүүжилт 49,338.4 сая төгрөг, ЭМД-ын санхүүжилт 779.0 сая төгрөг, нийт 69,122.0 сая төгрөг эх үүсвэр бүрдүүлэхээс, гүйцэтгэлээр ЭМД-ын санхүүжилт 262.9 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

Тусгай зориулалттай сангуудын батлагдсан төлөвлөгөөгөөр 3,832.9 сая төгрөгийн эргэн төлөлт төвлөрүүлэхээс 3,002.0 сая төгрөг бүрдүүлж 830.9 сая төгрөгийн эх үүсвэр дутуу бүрдүүлсэн байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг аймаг, сумдын ИТХ-ын хуралдаанаас нийт 26,947.1 сая төгрөгөөр тодотгон баталсан. Гүйцэтгэлээр нийт 38,676.3 сая төгрөгийн татварын ба татварын бус орлогыг төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөг 11,729.2 сая төгрөгөөр буюу 143,5 хувиар давуулан биелүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын батлагдсан төлөвлөгөө 18,662.0 сая төгрөг, гүйцэтгэлээр 26,238.8 сая төгрөг төвлөрч, төлөвлөгөөний биелэлт 140,6 хувь байна.
- Сумдын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын батлагдсан төлөвлөгөө 8,285.1 сая төгрөг, гүйцэтгэлээр 12,437.5 сая төгрөг төвлөрч, төлөвлөгөөний биелэлт 150,1 хувь байна.

Татварын орлогын төлөвлөгөө давж биелэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, аялал жуулчлал, аж үйлдвэрлэлийн чиглэлийн аж ахуйн нэгжүүдийг салбар нэгжээр бүртгэн авснаар цалингийн ашиг 3,791.3 сая төгрөг, ус ашигласны төлбөр 159.6 сая төгрөгөөр нэмэгдсэн.
- Сумдын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасны дагуу 14 суманд давхардсан тоогоор газрын дуудлага худалдааг явуулснаар аймгийн төсөвт 906.7 сая төгрөг төвлөрсөн.
- Цагдаа, шүүхийн шийдвэрийн байгууллага, татвар, аудитын байгууллагуудаас торгуулийн орлогоор 1,497.5 сая төгрөг төвлөрсөн.
- Ан агнуурын нөөц ашигласны төлбөрт шонхор шувууны 2,265.4 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.
- Иргэний нисэхийн газрын үл хөдлөх хөрөнгийн албан татварын дутуу төлөлт 2,711.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн.
- Малын тоо толгойн албан татварын хууль шинээр үйлчилж эхэлсэнтэй холбоотойгоор 932.1 сая төгрөг орон нутгийн орлогод төвлөрсөн.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр авч үзэхэд газрын төлбөрийг 1,248.8 сая төгрөгөөр, Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварыг 664.8 сая төгрөгөөр, Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 35.2 сая төгрөгөөр, Орон нутгийн өмч хөрөнгө борлуулсны орлогыг 142.0 сая төгрөгөөр, Төсөвт газрын өөрийн орлогыг 29.0 сая төгрөгөөр, түрээсийн орлого 1,4 сая төгрөгөөр, бууны албан татвар 0,2 сая төгрөгөөр, нийт 7 нэр төрлийн орлого 2,121.5 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Аймгийн Татварын хэлтсийн 2021 оны төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн мэдээг, Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн орон нутгийн орлогын гүйцэтгэлтэй тулгахад 5 сумын татварын орлогын мэдээ зөрөөгүй, 8 сумын татварын орлого 98.9 сая төгрөгөөр илүү, 14 сумын татварын орлого 28.0 сая төгрөгөөр дутуу буюу аймгийн Татварын хэлтэс нь нийт дүнгээр 70.9 сая төгрөгөөр илүү мэдээлсэн байна. Мөн аймгийн Татварын хэлтсийн төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн мэдээ нь сумдын татварын байцаагч нарын гаргасан мэдээнээс зөрүүтэй нийтлэг зөрчил байна.

2021 онд зарцуулах зарлагын гүйцэтгэл:

Аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд улсын төсвөөс санхүүжих тусгай зориулалтын шилжүүлэг 47,161.0 сая төгрөг, ОНХНС-ийн санхүүжилт 9,333.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 36,584.7 сая төгрөг, урьд оны шилжих үлдэгдлээс 2,463.4 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 516.2 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны бусад орлого 138.5 сая төгрөг, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 2,923.9 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 68.7 сая төгрөг, нийт 99,190.1 сая төгрөг төвлөрсөн байна.

Батлагдсан төлөвлөгөөнөөс Эрүүл мэндийн даатгалын сангаас 262.9 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого буюу зээлийн эргэн төлөлтөөс 759.1 сая төгрөг тус тус дутуу санхүүжигдсэн байна.

Аймгийн Засаг даргын 2021 онд зарцуулах зарлагын тодотгон батлагдсан төлөвлөгөө 108,663.7 сая төгрөг, зардлын нийт гүйцэтгэл 96,225.5 сая төгрөг буюу 12,438.2 сая төгрөгөөр дутуу зарцуулж, гүйцэтгэл 88,5 хувьтай байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар тайлант онд цалин, шимтгэлийн зардал 2,313.2 сая төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 735.1 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 58.1 сая төгрөгөөр, нормативд зардал 873.0 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 3.7 сая төгрөгөөр, дотоод албан томилолтын зардал 115.5 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, төлбөр хураамжийн зардал 52.1 сая төгрөгөөр, бараа ажил үйлчилгээний зардал 1,564.1 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэг

133.4 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 4,884.7 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх цэвэр зээл 1,705.3 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

Төсвийн зарцуулалтад дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол, 2021 оны 2 дугаар сарын 24-ны өдрийн “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 47 дугаар тогтоол, 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн “Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай” 187 дугаар тогтоол, 2021 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 93 дугаар тогтоолоор Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгосны дагуу зарим зардлуудад хязгаарлалт тогтоосон нь нөлөөлсөн.
- Бараа үйлчилгээний бусад зардал 1,564.1 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардал 133.4 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 4,884.7 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлээр 1,705.3 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь төсвийн зарлагыг хэмнэхэд нөлөөлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нэмэлт санхүүжилтийн дансанд хандив тусламжаар 360.3 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 8,285.5 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,047.1 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого 873.3 сая төгрөг, нийт 10,566.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Энэ нь өмнөх оноос 2,547.7 сая төгрөг буюу 31,8 хувиар өссөн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд тайлант хугацаанд 10,566.2 сая төгрөгийн эх үүсвэр бүрдсэнээс 10,018.4 сая төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 489.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлж, 15 сумын эмнэлэг болон өрхийн эмнэлгийн нэмэлт санхүүжилтийн харилцах данс 58.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтыг зардлын зүйлээр нь авч үзвэл цалин, НДШ-д 397.7 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 187.3 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 416.8 сая төгрөг, бусад урсгал зардалд 1,288.6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 458.6 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 4,942.6 сая төгрөг, тэтгэмж шагнал урамшууллын зардалд 2,234.7 сая төгрөг, хөрөнгийн зардалд 92.1 сая төгрөг, нийт 10,018.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь өмнөх оноос 3,292.1 сая төгрөг буюу 48.9 хувиар зардал өссөн байна.

Хүснэгт 9. Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

(сая төгрөг)

Зардлын үзүүлэлт	Мөнгөн	дүн
Цалин хөлс, Нийгмийн даатгалын шимтгэл		397.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		187.3
Хангамж, бараа материалын зардал		416.8
Норматив зардал		971.6
Эд хогшил, урсгал засварын зардал		306.3
Томилолт, зочны зардал		10.7

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	458.6
Бараа үйлчилгээний бусад зардал	4,942.6
Тэтгэмж, шагнал, урамшууллын зардал	2,234.7
Хөрөнгийн зардал	92.1
Зарлагын дүн	10,018.4

Эх сурвалж: Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас

- Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын зөрчлийн нэгтгэлээр Батсүмбэр, Баяндэлгэр, Мөнгөнморьт сумдын ЗДТГ-тай холбоотой 7.5 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоогдож, Сэргэлэн сумын ЭМТ, Мөнгөнморьт сумын ЗДТГ -т 18.6 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, аймгийн ИТХ, Лүн суман дахь сум дундын ойн ангитай холбоотой 1.3 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын төсвийн гүйцэтгэлийн Э-тайлангийн программыг ашиглан нэгтгэсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 188 төсөвт байгууллага, 4 хувийн өмчит сургууль, цэцэрлэг, 6 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 105 тусгай сан, 28 төрийн сангийн нэгж, 9 данс нийт 339 тайлан нэгтгэгдсэн байна. Үүнээс:

- Алтанбулаг, Угтаалцайдам сумдын байгаль хамгаалах сан хоосон мэдээлэлтэй, ЕБС, СӨБ ТЗШ-ийн хэмнэлт данс, Батсүмбэр ойн анги, Мах боловсруулах үйлдвэр өмнөх оны үзүүлэлтээр санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байна.
- Аймгийн хөрөнгийн барьцаа сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Орон нутгийн хөрөнгө оруулалт, Нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлт, Засаг даргын ерөнхий данс зэрэг данс нэгтгэгдсэн байна.
- Сангийн яамны Э-тайланд 19 сумын Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн санхүүгийн тайланг 17 сум Байгаль хамгаалах санд, Баян сум Мал хамгаалах санд, Баянчандмань сум орон нутгийн ерөнхий орлогын тайланд нэгтгэсэн өмнөх оны зөвлөмжөөр өгсөн зөрчлийг арилгаагүй байна.

Төрийн аудитын газар нь Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн 188 төсөвт байгууллага, 103 тусгай зориулалттай сан, 5 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 27 сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн, нийт 323 санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитад хамрагдсан 323 санхүүгийн тайлангаас 133 төсөвт байгууллага, 27 төрийн сангийн нэгж, 3 орон нутгийн өмчит байгууллага, нийт 163 санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргаж, 55 төсөвт байгууллага болон 103 тусгай сангууд, 2 орон нутгийн өмчит байгууллага, нийт 160 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Үүнд:

- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 27 санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт гаргаснаас 85,2 хувь буюу 23 санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй”, 7,4 хувь буюу 2 тайланд (Баян-Өнжүүл, Сэргэлэн сумдын санхүүгийн нэгтгэсэн тайланд) “Хязгаарлалттай”, 7,4 хувь буюу 2 тайланд (Дэлгэрхаан, Сүмбэр сумдын санхүүгийн нэгтгэсэн тайланд) “Татгалзсан” санал дүгнэлт өгөгдсөн.
- Төсвийн шууд захирагчийн 133 санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргаснаас 89,5 хувь буюу 119 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 7,5 хувь буюу 10 байгууллагын (Баянцагаан сумын ЕБС, СӨБ, ЭМТ, Дэлгэрхаан сумын ЕБС, СӨБ, Бүрэн, Сэргэлэн, Эрдэнэсант сумдын ЭМТ, Мөнгөнморьт, Батсүмбэр сумдын ЗДТГ-ын санхүүгийн тайланд) “Хязгаарлалттай”, 2,3 хувь буюу 3 байгууллагын (Аргалант сумын ЭМТ,

Сэргэлэн, Сүмбэр сумдын ЗДТГ-ын санхүүгийн тайланд) “Сөрөг”, 0,7 хувь буюу 1 байгууллага (Баян-Өнжүүл сумын ЭМТ-ийн санхүүгийн тайланд) “Татгалзсан” санал дүгнэлт өгөгдсөн.

- Орон нутгийн өмчит 3 аж ахуйн нэгж санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргаснаас 66,7 хувь буюу 2 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 33,3 хувь буюу Төв эрдэнэс ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд “Татгалзсан” санал дүгнэлт тус тус өгөгдлөө.

Төв аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, түүний харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 49,349.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 8,838.4 сая төгрөгийн алдааг залруулж, 217.1 сая төгрөгийн зөрчилд 132 төлбөрийн акт тогтоож, 11,702.4 сая төгрөгийн зөрчилд 248 албан шаардлага, 28,326.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 552 зөвлөмж, 265.1 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулахаар 9 албан шаардлага өгөгдсөн байна. Үүнээс 17,382.9 сая төгрөгийн алдаа зөрчил нь нийцлийн аудитын асуудал байна.

Аудитаар илэрсэн зөрчлийг төсөв захирагчаар ангилбал:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,844.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 41.1 сая төгрөгийн алдааг залруулж, 0.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,678.6 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага, 124.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгөгдсөн.
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 3,269.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 687.7 сая төгрөгийн алдааг залруулж, 15.0 сая төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт тогтоож, 802.4 сая төгрөгийн зөрчилд 19, хариуцлага тооцуулах 3 албан шаардлага, 1,764.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 36 зөвлөмж өгөгдсөн. Нийцлийн аудит буюу шилэн данстай холбоотой 2 албан шаардлага, 15 зөвлөмж өгөгдсөн байна.
- Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 13,563.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 7,925.7 сая төгрөгийн алдааг залруулж, 195.7 сая төгрөгийн зөрчилд 122 төлбөрийн акт тогтоож, 2,948.4 сая төгрөгийн зөрчилд 155, 265.1 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 4 албан шаардлага, 2,228.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд 265 зөвлөмж өгөгдсөн. Нийцлийн аудит буюу шилэн данстай холбоотой 17,351.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 2,151.2 сая төгрөгийн зөрчилд 22 албан шаардлага, 15,200.4 сая төгрөгийн зөрчилд 94 зөвлөмж өгөгдсөн байна.
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 308.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3.7 сая төгрөгийн алдааг залруулж, 23.9 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 281.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 9 зөвлөмж өгөгдсөн. Нийцлийн аудиттай холбоотой 31.3 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж, хариуцлага тооцуулахаар 1 албан шаардлага өгөгдсөн байна.
- Тусгай зориулалттай орон нутгийн сангуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 12,980.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 180.2 сая төгрөгийн алдааг залруулж, 5.9 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 4,097.9 сая төгрөгийн зөрчилд 38 албан шаардлага, 8,696.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 125 зөвлөмж өгөгдлөө. Нийцлийн аудиттай холбоотой зөрчилд 5 зөвлөмж өгөгдсөн байна.

3.8 Аудитын гол асуудал

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай” 2021 оны А/87 дугаар тушаалын дагуу аймгийн Засаг даргын харьяа төсөвт байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайланд хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, тусгай зориулалттай сан бүрээр төлөвлөн хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтийг шалгагдагч байгууллагын удирдлагад хүргүүлэн ажиллалаа. Үүнд:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд нь 27 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч, ЗДТГ, ИТХ, Соёлын төв, ОНХС, СХС, байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангуудын санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан.
- Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК, Дундманхайдай Аудит ХХК, Уваа-Уул Аудит ХХК-ууд 27 сумын ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, сум дундын Ойн анги, эмийн эргэлтийн сан, ОНӨААТҮГ-уудын санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан.

Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт, Ковид-19 цар тахлын үеийн арга хэмжээний зарцуулалт зэрэг асуудлуудыг аудитын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, тайлагналаа.

- Ковид-19 цар тахлын хувьд: Халдварын эсрэг дархлаажуулалтын санхүүжилтийг холбогдох журмын дагуу зарцуулсан эсэхэд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхэд ТШЗ-тай холбоотой нийт 103.3 сая төгрөгийн зөрчил илэрснийг 5.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 97.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлжээ.
- Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хувьд: Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад хөрөнгө бэлтгэсэн 249.4 сая төгрөг, Сургалт, семинар, хурал зэрэг арга хэмжээг цахим хэлбэрээр зохион байгуулж, албан томилолтын зардлыг хэмнээгүй 16.8 сая төгрөг, Засгийн газрын шийдвэр гарснаас бусад тэмдэглэлт ой, уралдаан тэмцээн зохион байгуулсан 2.2 сая төгрөг, Цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал урамшуулал олгохгүй байх гэснийг зөрчин урамшуулал олгосон 3.1 сая төгрөг, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах нэвтрүүлэг, контентыг санхүүжүүлэхгүй байх гэснийг зөрчин 2.0 сая төгрөгийг тус тус зарцуулсныг ТШЗ-ын тайланд зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлжээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн Засаг дарга шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 154 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон төлөвтэй 13, огт байршуулаагүй 23 мэдээлэл, хугацаандаа байршуулсан төлөвтэй 116 мэдээлэл байна.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлтийг хугацаандаа байршуулсан төлөвтэй боловч хөтөлбөрийн үр дүнгийн биелэлтийг гаргаагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аймгийн Засаг даргын Ерөнхий дансанд хэрэгжүүлэх горим сорилыг гүйцэтгэлийн үе шатанд нэмж, аудиторудын гүйцэтгэх хөтөлбөр, хуваарийг батлан хэрэгжүүллээ. Тус данснаас аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолоор баталсан ахмад настны хөгжил хамгаалал, урьд оны шилжих үлдэгдэл, Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага буюу хуваарилагдаагүй зардал, Авто зам, Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага, малын Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд гэсэн хөтөлбөр төслийг санхүүжүүлэн зарцуулдаг байна.

Аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Ахмад настны хөгжил хамгаалал хөтөлбөр арга хэмжээнд батлагдсан төлөвлөгөөний дагуу 103.5 сая төгрөгийг бүрэн санхүүжүүлсэн байна.
- Урьд оны шилжих үлдэгдлээс 11 арга хэмжээнд 3,500.0 сая төгрөгийг зарцуулахаар батлагдсан, гүйцэтгэлээр 2,753.3 сая төгрөг зарцуулсан ба 1 арга хэмжээ хэрэгжээгүй байна. Гүйцэтгэгч байгууллагад 2,571.9 сая төгрөг, захиалагчийн хяналтад 10.2 сая төгрөг, зураг төсөл зохиогчийн хяналтад 3.3 сая төгрөг тус тус олгосон ба холбогдох хууль тогтоомжийн дагуу суутгасан болон дутуу хийгдсэн ажлын 167.8 сая төгрөгийг барьцаа санд байршуулсан байна.
- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага буюу хуваарилагдаагүй зардалд 589.2 сая төгрөгийг төлөвлөгдсөнөөс, Ковид-19 цар тахлын үед халдвар хамгааллын хувцас, хэрэглэл, ариутгалын бодис, тоног төхөөрөмж, оношлуур, нэмэлт ор дэлгэх зэрэгт 287.1 сая төгрөгийг аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Онцгой байдлын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан. Тус зардлаас аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 295.3 сая төгрөгийг өвс тэжээл бэлтгэх, мах бэлтгэх, автомашины үнэнд, сумдын ЕБС-ийн 1,2-р хоолны тогоо, ногоон байгууламжийн хашаа, хүлэмжийн тоног төхөөрөмж, нарны зөөврийн цахилгаан үүсгүүр, хоол, шатахуун, бараа материалын зардалд зарцуулж, 6.8 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.
- Замын сангийн хөрөнгөөр 682.0 сая төгрөг батлагдаж, 13 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 1 ажил хийгдээгүй, 596.2 сая төгрөг зарцуулсан. Гүйцэтгэгч байгууллагад 575.9 сая төгрөг, захиалагчийн хяналтад 6.5 сая төгрөг олгосон ба тайлант хугацаанд хийгдсэн ажлуудаас 13.7 сая төгрөгийг барьцаа санд төвлөрүүлсэн байна.
- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага буюу байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 20 арга хэмжээг 752.5 сая төгрөгөөр гүйцэтгэхээр төлөвлөснөөс Заамар суманд 5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх ажлаас бусад ажил хийгдэж 678.1 сая төгрөг зарцуулсан. Гүйцэтгэгч байгууллагад 583.6 сая төгрөг, захиалагчийн хяналтад 9.5 сая төгрөг олгосон ба тайлант хугацаанд хийгдсэн ажлуудаас суутгасан болон дутуу хийгдсэн ажлуудын санхүүжилтээс авч үлдсэн 85.0 сая төгрөгийг барьцаа санд төвлөрүүлжээ.
- Малын Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд 132.0 сая төгрөг батлагдаж, аймгийн Засаг даргын А/178 дугаар захирамжаар вакцины үнэнд зарцуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцэхгүй, аймгийн Засаг даргын Ерөнхий данснаас Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага буюу хуваарилагдаагүй зардлаас зарцуулсан зарим ажил гүйлгээ нь Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар 3 зөвлөмж, 2 албан шаардлага, 1 төлбөрийн актыг хүргүүлж, 1 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.

Өмнөх аудитаар өгөгдсөн аймаг, сумдын төсөвт төвлөрүүлэх төсвийн орлогыг нэр төрлөөр жигд биелүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх, шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, иж бүрэн байршуулж ажиллах, Э-тайланд байгууллага, тусгай сангийн нэр, төрөл зөрүүтэй байгааг залруулах гэсэн 3 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас авсан зээлдэгч нараас 79.7 сая төгрөгийн зээлийн авлагыг барагдуулаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад тайлант онд төсвийн хуваарилагдаагүй зардлын зарцуулалтад илэрсэн зөрчлийг таслан зогсоосон

эсэхийг болон гадаад зээлээс зээлдүүлсэн зээлийн авлагын үлдэгдэлд дараагийн аудитаар анхаарал татахуйц байна.

4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 1,844.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 41.1 сая төгрөгийн алдааг залруулж, 0.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,678.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 124.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.2.1 Залруулсан алдаа

Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бараа материалын тодруулга тайланд 2.6 сая төгрөгийн бараа материалын орлого, зарлагыг хасах тэмдэгтэйгээр тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасан дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн Засгийн газрын хувь оролцоо дансанд 0.9 сая төгрөгийн элэгдлийн хасагдуулаг алдаатай тайлагнагдаж нэгтгэгдсэн, урьдчилгаа дансанд 37.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн гарзыг үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа дансанд бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасан дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2.2 Төлбөрийн акт

Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн стратеги төлөвлөлтийн хүрээнд сумдад ажилласан албан томилолтын 0.26 сая төгрөгийг илүү бодож олгосон, хүлээн авалтын зардалд 0.16 сая төгрөг, хоолны үнэнд 0.06 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5.-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын

тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасан дагуу төлбөрийн акт тогтоов.

4.2.3 Албан шаардлага

Аймгийн Татварын хэлтсийн 2021 оны төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн мэдээ нь сумдын татварын байцаагч нарын гаргасан мэдээнээс зөрүүтэй нийтлэг зөрчил илэрсэн ба санхүүгийн нэгтгэсэн тайлангийн орон нутгийн орлогын гүйцэтгэлээс 8 сумын татварын орлого 98.9 сая төгрөгөөр илүү, 14 сумын татварын орлого 28.0 сая төгрөгөөр дутуу буюу аймгийн Татварын хэлтэс нь нийт дүнгээр 70.9 сая төгрөгөөр илүү мэдээлсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг энэ хуульд заасан зарчимд нийцүүлэн Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” үүссэн бол албан шаардлага өгөх гэж заасан дагуу шийдвэрлэв.

Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан 2021 онд зарцуулах төсвийн зарлагын төлөвлөгөөг э-тайлангийн төлөвлөгөөтэй тулган шалгахад 27 суманд нийт 877.5 сая төгрөгийн зөрүүтэй нийтлэг зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.4-д “төсвийн захирагч нь төсвийн жилийн дундуур энэ хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тухайн жилийн төсөвтөө өөрчлөлт оруулж, зохицуулалт хийсэн бол гүйцэтгэлийг нь анхны батлагдсан зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулж тайлагнадаг байх”, 7 дугаар зүйлийн 7.5-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг тухайн жилийн төсвийг эрх бүхий байгууллагаас баталсан өдрөөс эхлэн зохион байгуулж болно”, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг энэ хуульд заасан зарчимд нийцүүлэн Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.5-д “төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн” бол албан шаардлага өгөх гэж заасан дагуу шийдвэрлэв.

Монбелиард үүлдрийн сүү махны чиглэлийн 34 толгой үхэр нийлүүлэх 425.0 сая төгрөгийн №ХХААГ/2021005 дугаартай гэрээг Нүүдэлчин агро ферм ХХК-тай байгуулж санхүүжилтийг 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр бүрэн шилжүүлж, авлага дансанд бүртгэлгүй зардалд бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “нягтлан болох бүртгэлийг стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” бол албан шаардлага өгөх гэж заасан дагуу шийдвэрлэв.

Түрээсийн орон сууцны орлогыг 2020 оноос төрийн сангийн 100140000961 дугаарын дансанд төвлөрүүлдэг болсноор Орон нутгийн өмчийн газарт бүртгэгдсэн 118.4 сая төгрөгийн авлага, өглөгийн барагдуулалтыг бүртгэх эрх зүйн орчныг бүрдүүлээгүй, аймгийн ИТХ-ын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн №05 дугаар тогтоолоор баталсан “Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-д болон НББ-ийн бодлогын баримт бичигт түрээсийн орон сууцны орлого, авлага, өглөгийг бүртгэх талаар тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7-д “авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй” бол албан шаардлага өгөх гэж заасан дагуу шийдвэрлэв.

Төсвийн хуваарилагдаагүй зардлаас 33.7 сая төгрөгөөр “Арвин ургац-Төв аймаг 2021” ургацын баярын арга хэмжээнд зарцуулсан. Энэ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-д “хууль ёс, дэг журам, аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах талаар”, а-д “хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6-д заасан “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” бол албан шаардлага өгөх гэж заасан дагуу шийдвэрлэв.

Төсвийн хуваарилагдаагүй зардлаас бэлтгэсэн хүлэмжийн тоног төхөөрөмж 8.5 сая төгрөг, нарны зөөврийн цахилгаан үүсгүүр 19.7 сая төгрөг, нийт 28.2 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагын данс бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “нягтлан болох

бүртгэлийг стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” бол албан шаардлага өгөх гэж заасан дагуу шийдвэрлэв.

Төсвийн хуваарилагдаагүй зардлаас Дүнжингарав дэвжээний бөхчүүдийн баяр наадмын бэлтгэлийн зардалд 13.0 сая төгрөг, худалдааны 100 жилийн ойд 10.0 сая төгрөг, Монголын хүнсчдийн холбооны 90 жилийн ойд 2.3 сая төгрөг, Ахмадын 90 жилийн ойн арга хэмжээний зардалд 7.9 сая төгрөг, шигшээ багийн зардалд 10.1 сая төгрөг, тэмцээний зардалд 1.7 сая төгрөг, нийт 45.2 сая төгрөгийг тэмдэглэлт ой, баяр наадам, уралдаан тэмцээнд зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5.-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.6-д заасан “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” бол албан шаардлага өгөх гэж заасан дагуу шийдвэрлэв.

Өмнөх аудитаар бичигдсэн аймгийн Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 19 иргэн, ААН-ийн 38.3 сая төгрөг, эзэн холбогдогч тодорхойгүй 41.3 сая төгрөг, нийт 79.7 сая төгрөгийн зээлийг тооцоо нийлж баталгаажуулан, үлдэгдлийг барагдуулах талаар бичигдсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. Төрийн аудитын тухай хуулийн 23 дугаар зүйл. Албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг хангах, 23.1-д “Төрийн аудитын байгууллага хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг Захиргааны ерөнхий хуулийн 82, 83 дугаар зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дүгээр зүйлийн 42.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” албан шаардлага өгөх гэж заасан дагуу шийдвэрлэв.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Аймгийн Засаг даргын хуваарилагдаагүй зардлаас Зэвсэгт хүчний 016-р ангид 13.0 сая төгрөг, Шүүхийг шийдвэр гүйцэтгэх албанд 2.5 сая төгрөг, Цагдаагийн газарт 4.4 сая төгрөг, аймгийн Татварын хэлтэст 10.0 сая төгрөг, аймгийн ЗДТГ-т 15.7 сая төгрөг, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт 4.8 сая төгрөг, Хүнс, Хөдөө аж ахуйн газарт 3.5 сая төгрөг, Хөл бөмбөгийн холбоонд 3.0 сая төгрөг, Засаг даргын захирамжаар хоолны үнэнд 27.3 сая төгрөг, шатахууны үнэнд 11.4 сая төгрөг, бичиг хэрэг, бараа материалын үнэнд 28.6 сая төгрөг, нийт 124.2 сая төгрөгийг улс, орон нутгийн төсөвт байгууллагуудын урсгал болон хөрөнгийн зардлыг санхүүжүүлж, төлбөрийг бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжийн харилцах дансанд шилжүүлсэн нь тухайн зардлууд захиалагч байгууллагын зардлын гүйцэтгэлд тайлагнагдахгүй, данс бүртгэлд тусгагдаагүй зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5.-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Аймгийн Засаг даргын ерөнхий данснаас улс, орон нутгийн төсөвт байгууллагуудын урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлдэг байдлыг таслан зогсоож, тус дансны санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах

2. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Аймгийн Засаг дарга шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 154 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон төлөвтэй 13, огт байршуулаагүй 23 мэдээлэл, хугацаандаа байршуулсан төлөвтэй 116 мэдээлэл байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлтийг хугацаандаа байршуулсан төлөвтэй боловч хөтөлбөрийн үр дүнгийн биелэлтийг гаргаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр байршуулж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

/сая төгрөгөөр/

Байгууллагын төрөл	Нийт алдаа, зөрчлийн		Залруулга		Үүнээс							
					Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал												
ТЕЗ	12	1,844.4	2	41.1	1	0.5	8	1,678.6			1	124.2
ТТЗ	83	3,269.4	17	687.7	8	15.0	19	802.4	3	0	36	1764.3
ТШЗ	726	13,563.3	180	7,925.7	122	195.7	155	2,948.4	4	265.1	265	2228.4
ОНӨҮГ	14	308.8	1	3.7			4	23.9			9	281.2
ОНТС	172	12,980.3	7	180.2	1	5.9	38	4,097.9	1		125	8696.3
Дүн	1,007	31,966.2	207	8,838.4	132	217.1	224	9,551.2	8	265.1	436	13,094.4
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал												
ТЕЗ	1	0									1	
ТТЗ	17	0					2				15	
ТШЗ	116	17,351.6					22	2151.2			94	15200.4
ОНӨҮГ	2	31.3							1		1	31.3
ОНТС	5	0									5	
Дүн	141	17,382.9	0	0	0	0	24	2,151.2	1	0	116	15,231.7
Нийт дүн	1,148	49,349.1	207	8,838.4	132	217.1	248	11,702.4	9	265.1	552	28,326.1